

“МИНИЙ ГЭР БҮЛ” төсөл

2018.05.03

Төслийн Уриалга: Архигүй, айдасгүй, дарамтгүй гэр бүлийн орчинг бүрдүүлье.

Төслийн зорилго: “Гэр бүлийн сар”-ын хүрээнд Эх үрсийн баярыг угтаж нийгмийн анхдагч нэгж болох гэр бүлийн гишүүдийн харилцаа, хариуцлага, үнэлэмж, үнэ цэнийг өсгөх, бие биеээ харилцан хүндэтгэсэн, эерэг дулаан уур амьсгалд хүүхэд бүр эцэг эхтэйгээ хамт хөгжиж, ирээдүйн Монгол иргэн зөвт хүн болон төлөвших, айдас, дарамтгүй , амар амгалан нийгмийг цогцлооход хувь нэмрээ оруулах, олны хайр, хүндлэл хүлээсэн шилдэг гэр бүлүүдийг тодруулах, сурталчлах, алдаршуулах зорилгоор энэхүү үйл ажиллагааг зохион явуулж байна.

Шалгуур үзүүлэлт:

1. Хөдөлмөрч, шударга
2. Бусдад үлгэр дууриалтай, нөлөөтэй, санаачлагатай манлайлагч
3. Ёс зүйтэй төв тэгш, зөв гэр бүл
4. Үр хүүхдүүдээ ажил, хөдөлмөрт сурган зөвт хүн болгон өсгөн хүмүүжүүлсэн
5. Холч , амьдралын ухаантай
6. Уламжлалт ёс заншлаа дээдлэн , амьдралын дадал болгосон
7. Нутаг усандаа нэр хүндтэй, ноён нуруутай , тусархаг
8. Байгаль эх, дэлхийгээ хайрлан, нутаг усаа дээдэлдэг
9. Нэр дэвшүүлэх гэр бүлийн хүүхдийн тоо 4-өөс дээш байна

Хамрах хүрээ: Аймгийн хэмжээнд

Нэр дэвшүүлэх үйл ажиллагаа: Сум, багийн Засаг дарга нар, байгууллагын удирдлага, өөрсдөө, үр хүүхдүүд нь

Хугацаа: -Нэр дэвшүүлэх, санал авах хугацаа: 2018 оны 5-р сарын 10-26 хүртэл .
Нэр дэвшигдэх өрхийн танилцуулга материалыг “Дундговийн эмэгтэйчүүд” facebook групп дээр байршуулна.

Шалгаруулалт: Хамгийн их олон нийтийн хандалт авсан бахархал бүхий 9 гэр бүлийг аймгийн Эмэгтэйчүүдийн Холбооны Удирдах зөвлөл, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэстэй хамтран тодруулна.

Алдаршуулах ёслолын арга хэмжээ: Шилдэг гэр бүлүүдийг алдаршуулах үйл ажиллагаа 5-р сарын 30 –ны өдөр аймгийн ТХДЖ-ийн театрт болно.

Жич: Нэр дэвшиж байгаа гэр бүлийн талаар сөрөг \нэр хүндийг гутаах, доромжлох г.м\ мэдээлэл бичих, мэдээлэлийн эх сурвалжийг өөр зүйлд ашиглахыг хориглоно.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗАР

АЙМГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН

ХОЛБОО